

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/183/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Авирмэд Утас: 70453799, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА  
Д.ЦОГТ-ОЧИР ТАНАА

2022.02.24 № ЧБА - 2022/123/НА-СТА-ТШЗ  
танай -ны № -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

  
М.БАТСУУРЬ

0200200275

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан .....	4
3.1 Ерөнхий зүйл .....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	7
3.4 Материаллаг байдал.....	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	9
3.8 Аудитын гол асуудал.....	9
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	9
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	10
4. Аудитын илрүүлэлт.....	10
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	11

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
.	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ [2]+[3]	745,816.22	286,640,450.27
3101	Кассад байгаа бэлэн мөнгө	0	0
3102	Банканд байгаа бэлэн мөнгө/төгрөг/	745,816.22	286,640,450.27
310201	Банканд байгаа бэлэн мөнгө/Улсын төсөв/	745,816.22	286,640,450.27
3.1.4.1	Банканд байгаа бэлэн мөнгө/ОН-ийн төсөв/	0	0
.	АВЛАГА	0	0
33	Улсын төсвийн авлага	0	0
33	Хувь хүмүүсээс авах авлага улсын төсөв	0	0
33	Байгууллагаас авах авлага улсын төсөв	0	0
33	Орон нутгийн төсвийн авлага	0	0
33	Байгууллагаас авах авлага	0	0
33	Хувь хүнээс авах авлага	0	0
33	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	745,816.22	286,640,450.27
.	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0	0
.	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	745,816.22	286,640,450.27
41	Богино хугацаат өр төлбөр	-	-
4.1	Өглөг	-	-
4101	Хэлтэс хоорондын тооцоо	0	0
410101	Байгууллага хоорондын тооцоо УТ	0	0
410102	Байгууллага хоорондын тооцоо ОН	0	0
410301	Хувь хүнд өгөх улсын төсвийн өглөг	-	-
410302	Хувь хүнд өгөх ОН-ийн төсвийн өглөг	0	0
410302	Байгууллагад өгөх ОН-ийн төсвийн өглөг	0	0
4	Урьдчилж орсон орлого	0	0
41040101	Урьдчилж орсон орлого Улсын төсөв	0	0
41040102	Урьдчилж орсон орлого Орон нутаг	0	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
41	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0	-
41	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
510301	Өмнөх үеийн үр дүн	18,116.13	745,816.22
5103010002	Өмнөх үеийн үр дүн орон нутаг	0	0
510302	Тайлант үеийн үр дүн	727,700.09	285,894,634.05
5103020002	Тайлант үеийн үр дүн орон нутаг	0	0
0	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	0	0
0	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	745,816.22	286,640,450.27

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>14,382,784,943.72</b>	<b>5,996,514,115.34</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,391,453.72	100,115.34
120	Нийтлэг татварын бус орлого	4,391,453.72	100,115.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,391,453.72	57,505.69
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,391,453.72	57,505.69
120009	Бусад орлого		42,609.65
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>14,378,393,490.00</b>	<b>5,996,414,000.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	14,063,339,190.00	5,851,264,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	14,063,339,190.00	5,851,264,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	315,054,300.00	145,150,000.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	315,054,300.00	145,150,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>14,382,057,243.63</b>	<b>5,710,619,481.29</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,382,057,243.63	5,710,619,481.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,384,000.00	26,991,050.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,384,000.00	26,991,050.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,384,000.00	24,960,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,000,000.00	2,031,050.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,359,673,243.63	5,683,628,431.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,302,294,137.16	5,628,781,000.53
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	14,302,294,137.16	5,628,781,000.53
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	57,373,150.63	845,930.76
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	57,373,150.63	845,930.76
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,955.84	54,001,500.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,955.84	54,001,500.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>727,700.09</b>	<b>285,894,634.05</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>727,700.09</b>	<b>285,894,634.05</b>

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>14,382,784,943.72</b>	<b>5,996,514,115.34</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,391,453.72</b>	<b>100,115.34</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,391,453.72	100,115.34
120002	Хүүгийн орлого	4,391,453.72	57,505.69
120009	Бусад орлого		42,609.65
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>14,378,393,490.00</b>	<b>5,996,414,000.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	14,063,339,190.00	5,851,264,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	14,063,339,190.00	5,851,264,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	315,054,300.00	145,150,000.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	315,054,300.00	145,150,000.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>14,382,057,243.63</b>	<b>5,710,619,481.29</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>14,382,057,243.63</b>	<b>5,710,619,481.29</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>22,384,000.00</b>	<b>26,991,050.00</b>
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	22,384,000.00	26,991,050.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,384,000.00	24,960,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,000,000.00	2,031,050.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>14,359,673,243.63</b>	<b>5,683,628,431.29</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	14,302,294,137.16	5,628,781,000.53
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	14,302,294,137.16	5,628,781,000.53
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	57,373,150.63	845,930.76
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	57,373,150.63	845,930.76
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	5,955.84	54,001,500.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,955.84	54,001,500.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>727,700.09</b>	<b>285,894,634.05</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	727,700.09	285,894,634.05
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	18,116.13	745,816.22
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	745,816.22	286,640,450.27

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 01 сарын 1-ээрх үлдэгдэл	0	0	-	0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	0	0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0	0	0	0
7	Тайлант үеийн үр дүн	0	0	0	0
8	2020 оны 01 сарын 1-ээрх үлдэгдэл	0	0	745,816.22	745,816.22
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	0	0
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0	0	0	0
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0	0	0	0
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	0	0	0	0
14	Тайлант үеийн үр дүн	0	0	285,894,634.05	285,894,634.05
15	2021 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	0	0	286,640,450.27	286,640,450.27

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		745,816.22
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	10,908,682,000.00	5,655,772,050.53
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	10,908,682,000.00	5,655,772,050.53
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	10,908,682,000.00	5,655,772,050.53
<b>Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж</b>	<b>10,871,450,000.00</b>	<b>5,628,781,000.53</b>
Халамжийн тэтгэвэр	4,800,000,000.00	1,163,476,970.00
Халамжийн тэтгэмж	2,023,000,000.00	1,538,826,204.00
Амьжиргаа дэмжих мөнгөн тусламж	1,345,000,000.00	1,100,568,760.00
ХБИ-д үзүүлэх тусламж	818,300,000.00	337,278,735.00
Хүнс тэжээл /Улсын төсөв/	480,000,000.00	1,002,279,731.53
Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	1,260,000,000.00	395,202,100.00
ОНО-нд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	20,350,000.00	20,348,500.00
Амьжиргаа дэмжих мөнгөн тусламж	124,800,000.00	70,800,000.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>37,232,000.00</b>	<b>26,991,050.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,232,000.00	24,960,000.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	12,000,000.00	2,031,050.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	10,908,682,000.00	5,942,412,500.8
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	10,763,532,000.00	5,851,264,000.00
Улсын төсвөөс санхүүжих	10,763,532,000.00	5,851,264,000.00
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	145,150,000.00	91,148,500.00
Орон нутгийн төсвөөс	145,150,000.00	91,148,500.00
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	0.80
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		0.80

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 34 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Халамжийн сан нь нь иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБООУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 115.0 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,996.4 сая төгрөгийн 1 хувь буюу 59.9 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 47.9 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоолоо.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 285,894.6 мянган төгрөгөөр буюу 383 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан данс байхгүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	745.8	286,640.4	285,894.6
Авлага			
Урьчилгаа			
Бараа материал			
Үндсэн хөрөнгө			
<b>Нийт хөрөнгө</b>	<b>745.8</b>	<b>286,640.4</b>	<b>285,894.6</b>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо/ээздийн өмч/	745.8	286,640.4	285,894.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>745.8</b>	<b>286,640.4</b>	<b>285,894.6</b>

Нийт хөрөнгө 286,640.6 төгрөг болж өмнөх оноос 383 хувиар өссөн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өссөнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 8,386,313.4 мянган төгрөгөөр буюу 41.6 хувиар буурсан байна. Энэ нь халамжийн үйлчилгээ цахимд шилжсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 8,672,220.2 мянган төгрөгөөр буюу 39.7 хувиар буурсан байна. Энэ нь халамжийн үйлчилгээ цахимд шилжсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 16,254,948.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 16,254,948.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 5,346,266.0 мянган төгрөгөөр бууруулж 10,908,682.0 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 57 төрлийн үйлчилгээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 10,763,532.0 мянга, орон нутгийн төсвөөс 145,150.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,851,264.0 мянга, орон нутгийн төсвөөс 91,148.5 төгрөгийн санхүүжилт авч нийт 5,942,412.5 орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 5,655,772.1 мянган төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 54,001.5 мянга, улсын төсөвт хүүгийн орлого 845.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж 286,640.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,655,772.1 мянган төгрөг буюу 92.0 хувьтай байгаа нь зардлыг 54,001.5 төгрөгөөр хэмнэж, хүүгийн орлого 57.5 мянга, бусад орлого 42.6 мянган төгрөг олж, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 745.8 мянга, эцсийн үлдэгдэл 286,640.4 мянган төгрөг байгаатай холбоотой байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Халамжийн сангийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх аудитаар илэрсэн байсан тул шилэн дансны үйл ажиллагааг аудитад хамруулан шалгав.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх аудитаар шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөж ажиллах зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажиллаж биелэлтийг 2021 оны 04 сарын 30-ны өдрийн 418 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 1,200.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,200.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

### **4.2 Төлбөрийн акт**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтад "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Нийгмийн халамжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт "Халамжийн сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно" гэж заасныг зөрчин Халамжийн сангаас Тэс сумын иргэн Ц.Баатаржавт онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжийг давхар олгож төрд 1,200.0 мянган төгрөгийн хохирол учруулсан алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган.төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Халамжийн сан	1	1,200.0			1	1,200.0				
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1,200.0</b>			<b>1</b>	<b>1,200.0</b>				

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Handwritten signatures and a red square stamp are present over the signature lines. The stamp contains the text 'АУДИТЫН ТАЙЛАНГ' and '2022.02.16'.

/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Б.АВИРМЭД/

2022 оны 02 сарын 16-ны өдөр